



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/271

Булган сум

Шууд худалдан авах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.9 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас хэрэгжих “Аялал жуулчлалын аппликейшн хийх” байгууллагаар РД:7024409 регистрийн дугаартай “Альфа фокс солюшн” ХХК-тай 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д олгосугай.

2.“Аялал жуулчлалын мэдээллийн сан” бүхий аппликейшнийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан мэдээлэл бүхий аппликейшнийг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Альфа фокс солюшн” ХХК-ийн захирал (Г.Амарцог)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Д.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

5.Аппликейшнийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөгжүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ЛҮРЭВ-ОЧИР

